



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/183

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Кинза трейд" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг, Тэмүүжин цогцолбор сургуулийн зүүн талд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай газраас 10759 м² газрыг иргэн Уртнасангийн Одхүүд шилжүүлэн, үлдсэн 7958 м² газрыг "Кинза трейд" ХХК-д эзэмшүүлсүгэй.

2. "Кинза трейд" ХХК болон иргэн У.Одхүүгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Кинза трейд" ХХК болон иргэн У.Одхүүд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2003 оны 211 дүгээр захирамжийн хавсралтын 4 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 935

D:\My Documents\Захирамж 2017.doc